

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын
2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/07
дугаар тушаалын 18 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамж, Газрын захирлын тушаалаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн огноо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамж

Дагаж мөрдөх огноо: 2023.04.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.03.31

1. Байгууллагын нэр	2. Нэгжийн нэр
“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГазар	Тохижилт үйлчилгээний алба
Албан тушаалын нэр: Ерөнхий инженер	Албан тушаалын ангилал Зэрэглэл: ТҮ-9
Ажлын цаг: 8/40	Ажлын байрны албан ёсны байршил: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 32-р хороо, Хүй долоон худаг
Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн	Онцгой нөхцөл: Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Хүй долоон худгийн барилга байгууламж, бүтээн байгуулатыг зураг төслийн дагуу угсарч барих ажлыг удирдан зохион байгуулах, инженерийн зөвлөгөө өгөх, барилгын норм, дүрэм, стандарт, техникийн нөхцлийн шаардлагыг хангах, хяналт тавих

Албан тушаалын зорилт:

- Барилга байгууламжийг зураг төслийн дагуу угсарч барих ажлыг удирдан зохион байгуулах, барилгын норм, дүрэм, стандарт, техникийн нөхцөл шаардлагыг хангах, хяналт тавих
- Хүй долоон худаг дахь ус, цахилгаан, дулаан гэх мэт дэд бүтцийн ажлыг технологи, батлагдсан төлөвлөгөө, зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх, хяналт тавих
- Хүй долоон худгийн барилга, байгууламж, дэд бүтэцтэй холбоотой засвар үйлчилгээний захилага гаргах, төсөв боловсруулах, хийж гүйцэтгүүлэх, хяналт тавих
- Хүй долоон худагт зохион байгуулагдах Үндэсний их баяр наадам болон бусад арга хэмжээний үед цахилгаан хангамж, радио үзель болон шугам сүлжээний ажлуудын бэлэн байдлыг хангах
- Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг чанд мөрдөх.
- Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан
--------	------------------------------------	-------------------------------	---

			гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Барилга байгууламжийн төлөв байдлыг үнэлэх, бат бөх чанарыг тооцоолох, зураг төсөл зохиох, норм дүрмийн шаардлагыг ханган ажиллах	Норм дүрмийн биелэлт хангагдсан байна.	Г
	2. Барилгын ажлыг удирдан зохион байгуулах, инженерийн хяналт тавих, барилга угсралтын явц, төлөвлөгөөний биелэлт болон материал, бүтэц, эзэлхүүний чанар, хийцэд зураг, төсөв, барилгын норм, дүрэм стандарт, техникийн нөхцлийн дагуу хяналт тавих	Стандартын биелэлт хангагдсан байна.	Г,Х
	3. Барилга, байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдолтой дүрэм, журам, заавар, стандартуудын хэрэгжилтэнд хяналт тавих	Стандартын биелэлт хангагдсан байна.	Г,Х
	4. Барьж дуусгасан барилга байгууламжийг техникийн комисст хүлээлгэн өгөх, холбогдох бичиг баримтыг бэлтгэн тавих	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5. Худалдан авах ажиллагааны хүрээнд хийгдэх барилга байгууламжийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажлуудыг оновчтой тодорхойлох	Хэрэгжилт хангагдсан байна	Г,Х
	6. Байгууллагын ажилтнуудын ашиглавал зохих МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол, НИТХ-ын тогтоол, НЗД-ын тушаал, захирамж, журам заавар, байгууллагын даргын тушаал, байгууллагын дүрэм, дотоод журам, норм норматив, стандарт зэрэг тогтоомжийн лавлах /эрх зүйн актуудын эмхтгэл/-ийн дагуу үр дүнтэй ажиллах	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	7. Ерөнхий инженерийн сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан тогтсон хугацаанд тайлагнан удирдлагад танилцуулан ажиллах.	Төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Барилга, дулаан, усан хангамж ариутгах татуурга, цахилгааны угсралт, өргөтгөл шинэчлэлт, их засварын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, дүгнэх зохиогчийн хяналт хийлгэх, гэрээний биелэлтийг хангуулах	Хэрэгжилт хангагдсан байна	Г,Х
	2. Хаягжуулалтын ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх	Хэрэгжилт хангагдсан байна	Г
	3. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай удирдан зохион байгуулах	Хэрэгжилт хангагдсан байна	Г

	<p>4. Холбогдох мэдээ, тайланг цаг хугацаанд нь гаргаж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах</p> <p>5. Ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой байгууллагын дарга болон албаны ахлах мэргэжилтэнгээс өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн, тайлагнаж, уялдаа холбоотой хамтран ажиллах.</p> <p>6. Байгууллага, нэгжээс зохион байгуулж байгаа аливаа сургалт, мэдээлэлд цаг тухай бүрд нь хамрагдах</p>	<p>Тухай бүрд хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Хэрэгжилт хангагдсан байна</p> <p>Хэрэгжилт хангагдсан байна</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. ёс зүйн дүрэм сахилга хариуцлага захирах захирагдах ёсыг баримтлан ажиллах</p> <p>2. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах</p> <p>3. Батлагдсан ХХНЖ-ын хүрээнд баримт бичгийн заавар журмын дагуу бүрдүүлэх, хугацаанд нь архивт шилжүүлэх</p> <p>4. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах.</p> <p>5. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах</p>	<p>Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Стандартын хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Архивын заавар стандартад нийцсэн байна.</p> <p>Дүрмээр хүлээсэн үүрэг хангагдсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Т</p> <p>Т</p>


III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил	Барилгын инженер, Архитектор
Мэргэшил	Мэргэшсэн инженер байх
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай байх.
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Бүтээлч сэтгэлгээ (шинэчлэн сайжруулах, шинийг зохиомжлох, зургаар илэрхийлэх, оновчтой шийдэл сонгох, үр дүнд хүргэх - Орон зай дүрслэлийн хөгжингүй сэтгэлгээ, математик тооцооллын чадавхи - Нягт нямбай, хичээнгүй зан чанар - Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, асуудлыг түргэн шийдвэрлэх - Монгол хэл бичгийн зөв бичих, найруулгын мэдлэгтэй - Компьютерийн хэрэглээний болон зургийн программууд дээр ажиллах чадвартай, техник сэтгэлгээтэй - Хэл яриа /тодорхой ойлгомжтой ярь, тайлагнах/-ны чадвартай - Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр: Газрын дарга Тохижилт үйлчилгээний албаны захирал	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Архитектур-1 Ашиглалтын инженер-1	Бусад харилцах субъект: 1. Хамтран ажиллаж буй гэрээт байгууллага болон хувь хүн

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн: <i>А. Цэнгэлсайхан</i> А.Цэнгэлсайхан 2023 оны 03 дугаар сарын 31 ны өдөр	“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Дарга С.Сайнбаяр (Тамга, тэмдэг)  2023 оны 03 дугаар сарын 31 ны өдөр